ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/118 Амардалай

Хүрдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 6 дугаар зүйлийн 6.2, 24 дүгээр зүйлийн 24.3, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол,Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/36 тушалаар батлагдсан "Насанд хүний ажилллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын 3.10.2, Хүний эрхийн Үндэсний комиссын 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 05/02 дугаар зөвлөмж, Аймгийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/76 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсэрт жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, бооцоот болон мялаалга найрын уралдаан, үсэргээ, сунгаа, зохион байгуулах, оролцохыг хориглосугай.

2.Байгаль цаг агаарын таагүй нөхцөлд хурдан морины уралдаанаас үүсч болох эрсдлийг иргэд, олон нийт, уяач, эцэг, эхчүүдэд сурталчилан таниулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын "Дэлгэрэх хүлэг"морин спорт уяачдын холбооны тэргүүн (Н.Загдхорол), сумын "Хүүхэд хамгааллын хамтарсан баг"-т үүрэг болгосугай.

3. Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулсан тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллахыг цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Л.Отгонбаатар) -т үүрэг болгосугай.

ДАРГА М.БАЯРСҮХ

4880200517